

## ГЭР ОРОНГҮЙДЭЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН: УЛААНБААТАР ХОТЫН ЖИШЭЭГЭЭР

**Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг<sup>1</sup>**, магистр, Когнос интернэйшнл ХХК-Судалгаа, үнэлгээний компанийн захирал

**Батцэнгэлийн Мөнхжаргал<sup>2</sup>**, доктор, Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургуулийн ахлах багш

**Төмөртолгойн Навч**, магистр, Хүн амын сургалт, судалгааны төвийн судлаач

### Хураангуй

Хүн бүр “хөгжлөөс үл орхигдох” эрхтэй ч Монгол Улсад гэр оронгүйдлийн талаарх ойлголт, тодорхойлолт цэгцрээгүй, тоо мэдээ, судалгаа дутмаг байгаагаас бусдын нүдэнд гэр оронгүй гэж шууд харагдахгүй ч олон улсын стандартаар “гэр оронгүй” ангилалд орох хүмүүс бий болоод удаж байна. Судалгаанд i) Олон улсын ойлголтод суурилан Монгол Улс дахь “гэр оронгүйдэл”-ийн тоо хэмжээг тогтоох, ii) Гэр оронгүй иргэдийн шинж байдал, гэр оронгүйдлийн шалтгааныг судлах зорилтууд дэвшүүлсэн. Шинжилгээнд ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллого, нийслэлийн захиргааны хэвлэгдээгүй тайлангууд, Когнос интернэйшнл ХХК-ийн 2022 оны судалгаа<sup>3</sup> зэрэг хоёрдогч мэдээллүүд ашиглан баримт бичгийн судалгаа, “дүрслэх статистик”-ийн ба чанарын судалгааны “сэдэвчилсэн” шинжилгээнүүд хийсэн. Хүн амьдрах зориулалтгүй сууцанд амьдарч буй өрхийн тоо 2020 оны ХАОСТ-оор улсын хэмжээнд 8,039, Улаанбаатарт 2,227 байна. Харин НЗДТГ-ын мэдээгээр Улаанбаатарт 2022 онд 6,779 өрх зориулалтын бус сууцанд, үүнээс 1,857 нь орон сууцны орц, подваль, 00 өрөөнд амьдарч байна. Түүнчлэн Улаанбаатарт тэнэмэл иргэдийн тоо 2020 оны эцэст 850 хүрсэн ба 2023 онд нэмж 256 иргэн “гэр оронгүй болсон” хэмээн орон байраар түр хангах улсын үйлчилгээнд хамрагджээ. Улаанбаатар дахь тэнэмэл иргэдийн дийлэнх эрэгтэй, дунджаар 48.3 настай, бэлэвсэн юуу гэр бүл салсан, тал хувь нь 7-оос дээш жил хэсүүчилж байгаа бол зориулалтын бус сууцанд амьдрагчдын дийлэнх эмэгтэй, өрх толгойлсон, дунджаар 46.4 настай, тал хувь нь 5-аас дээш жил зориулалтын бус сууцанд амьдарч байна. Гэр оронгүй болсон шалтгаанууд нь тэнэмэл иргэдийн хувьд ихэвчлэн хувь хүн, гэр бүлийн холбогдолтой, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хувьд “тогтолцооны” холбогдолтой байна.

**Түлхүүр үгс:** гэр оронгүй иргэд; тэнэмэл иргэд; зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд; гэр оронгүйдэл; гэр оронгүйдлийн шалтгаан

### HOMELESSNESS AND ITS REASONS: A CASE OF ULAANBAATAR CITY

#### Abstract

“No one should be left behind”, but due to the lack of understanding and definition of homelessness in Mongolia, coupled with insufficient data and research, there have long been people who are classified as “homeless” by international standards, despite not being perceived as such by others. The study aims to achieve two main objectives: i) to determine the number of “homelessness” in Mongolia based on international understanding, and ii) to investigate the characteristics of homeless people and underlying reasons for homelessness. Utilizing document review, “descriptive statistics” and “thematic” analyzes of qualitative research, secondary data sources such as the Population and Housing Census of the National Statistical Office (NSO), unpublished reports of the capital city administration, and a study conducted by Cognos International LLC in 2022 were analyzed. According to the 2020 Population and Housing Census, there were 8,039 households nationwide and 2,227 in Ulaanbaatar living in places not intended for human habitation. However, capital’s administrative data from 2022 indicates that 6,779 families in Ulaanbaatar reside in places not intended for human habitation, with 1,857 living in entrances, basements, and makeshift accommodations. In addition, the number of street homeless individuals in Ulaanbaatar reached 850 by end of 2020, with 256 new citizens enrolled in state services for temporary

<sup>1</sup> Холбоо барих зохиогч. Хаяг: erdenechimeg@cognos.mn

<sup>2</sup> Холбоо барих зохиогч. Хаяг: Munkhjargal\_b@num.edu.mn

<sup>3</sup> Өгүүлэлд Азийн Хөгжлийн Банкны захиалга, санхүүжилтээр Когнос интернэйшнл ХХК-ий хийсэн “Улаанбаатар хотын гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг үнэлэх” түргэвчилсэн судалгааны тоо мэдээллийг хоёрдогчоор ашигласан. Анхдагч мэдээлэл цуглуулах ажилд оролцсон судлаач С.Болормаа, С.Туяа, Т.Сүмжидмаа, Н.Батсүх, Б.Сугар, Ц.Цогтбаяр, Б.Намуун, Л.Баянмөнх нарт талархал илэрхийлье.

housing in 2023. The majority of the street homeless people in Ulaanbaatar are men, averaging 48.3 years of age, often widowed or divorced, with half living in these conditions for over 7 years. Conversely, those living in places not intended for human habitation are predominantly women, female-headed families, averaging 46.4 years of age, with half living in such conditions for over 5 years. While personal and family-related factors often contribute to street homelessness, “structural” issues/reasons play a significant role for those living in places not intended for human habitation.

**Key words:** homeless people; street homeless; people living in places not intended for human habitation; homelessness; reasons of homelessness

## 1. ОРШИЛ

Гэр оронгүйдлийн асуудал нь хувь хүн орон байрны аюулгүй орчинд амьдрахаас хамаагүй өргөн хүрээтэй бөгөөд тухайн иргэн гэр бүлээ алдах, гэр бүл, хамаатан садангүй амьдрах, нийгмээс гадуурхагдах, хүлээн зөвшөөрөгдөхөө болих зэрэг асуудалтай холбогддог өргөн хүрээтэй ойлголт юм (58th UN Commission for Social Development, 2020). Гэр оронгүй байх нь хувь хүний эдийн засгийн боломжийг багасгаж, нийгмээс хөндийрүүлдэг төдийгүй биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, өөрийгөө үнэлэх үнэлэмж, нэр хүндэд хүртэл сөргөөр нөлөөлдөг үзэгдэл байдаг (Sylvestre J., Kerman, N., Polillo, A., Lee, C.M., Aubry, T., & Czechowski, K., 2018; Oppenheimer, Sarah, C., Paula, S., Nurius, & Green, S., 2016; Tan, H., Forbes-Mewett, H., 2018).

Хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнөөс үүдсэн хотуудын хүн амын өсөлт, бодит цалингийн өсөлтийн удаашрал, орон байрны түрээсийн үнийн өсөлт, орон сууцны зах зээлд иргэдийн худалдан авах чадвар буурсан, орон сууцны зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал, түрээсийн үнэ нь өрхийн сарын орлогын 30 хувиас доош байдаг хүртээмжтэй орон сууцны хүрэлцээ дутмаг, эсхүл хомсдолтой байдал зэрэг нь дэлхийн олон хотод гэр оронгүйдлийн хямралыг бий болгоход нөлөөлж байна (58th UN Commission for Social Development; UN-HABITAT, 2020). Мөн хөдөө орон нутагт хүн амын амьжиргааны түвшин доогуур, суурь үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь хөдөөгийн иргэд хот, сууринд орон гэр нь бэлэн биш байхад олноор шилжин суурьшиж, улмаар гэр оронгүйдэлд өртөхөд хүргэж байна (58th UN Commission for Social Development, 2020).

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаас харвал, олон оронд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдын дунд гэр оронгүйдэл, гэр оронгүй иргэдийн асуудлыг анхааран авч үзэх хандлага хангалтгүй байна. Тухайлбал, даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтууд нь дэлхийн улс орнуудын хүн амын сайн сайхан байдлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ба “Хэнийг ч хөгжлөөс үл орхих” гэсэн зарчимд тулгуурладаг боловч түүний аль ч зорилго, шалгуур үзүүлэлтэд гэр оронгүй иргэдийн талаар дурьдагдаагүй байдаг. Түүнчлэн Монгол Улсыг оролцуулаад дэлхийн олон хөгжиж буй орны хөгжлийн бодлого, эрх зүйн орчинд гэр оронгүй хүмүүсийн талаарх ойлголт, тодорхойлолт, тоо мэдээлэл, статистик, судалгаа ихээхэн дутагдалтай, түүнээс улбаалан шаардлагатай бодлого, хөтөлбөрүүд байхгүй, эсхүл хангалтгүй хэрэгждэг.

Монгол Улсын хувьд тогтсон гэр оронгүй тэнэмэл иргэдийг л “гэр оронгүй” гэх ангилалд багтаан ойлгодог хандлага олон жил байсаар байна. Гэвч бусдын нүдэнд гэр оронгүй гэж шууд харагдахгүй ч олон улсын стандартаар авч үзвэл “гэр оронгүй” гэсэн ангилалд орох хүн амын бүлэг Монгол Улсад бий болоод удаж байна. Түүнчлэн гэр оронгүйдэл, гэр оронгүй иргэний талаарх ойлголт, тодорхойлолтууд цэгцрээгүй, тоо мэдээлэл, судалгааны ажлууд дутмаг, асуудлыг бодлогын түвшинд авч үзэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх байдал ховор байна. Гэр оронгүйдлийн асуудлыг олон улсын туршлагаар шинэ өнцгөөс харах, ойлгох, судлах, шийдэх зэрэгт анхаарахгүй байх нь нийгэмд олон сөрөг үр дагавар үлдээх боломжтой. Тухайлбал

хэн ч “хөгжлөөс үл орхигдох” эрхтэй боловч нийгмийн зарим бүлэг хөгжлийн гадна орхигдох, түүнчлэн одоогийн хууль, эрх зүйн хүрээнд “гэр оронгүй” ангилалд орохгүй байгаа ч бодит амьдралын нөхцөл байдлаараа “гэр оронгүй”-д тооцогдож болох хүн ам нэмэгдэх, нөхцөл байдал нь дордох, улмаар нийгэмд эмзэг бүлгийн иргэд нэмэгдэх зэрэг эрсдэл байгаа юм. Иймд энэ судалгаагаар дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Олон улсын ойлголт, хандлагад суурилсан байдлаар Монгол Улс дахь “гэр оронгүй иргэд”-ийн тоо хэмжээг тогтоох
2. Улаанбаатар хот дахь гэр оронгүй иргэдийн нийтлэг шинж байдлыг тодорхойлох
3. Улаанбаатар хот дахь иргэдийн гэр оронгүйдлийн шалтгааныг судлах<sup>4</sup>.

Судалгааны ач холбогдол нь i) Монгол Улс дахь гэр оронгүйдэл, гэр оронгүй иргэдийн талаарх ойлголт тодорхойлолтыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн цэгцлэхэд хувь нэмэр оруулах, ii) Гэр оронгүй иргэдтэй холбоотой боломжит эх үүсвэрийн мэдээллүүдийг нэгтгэн тоймлосноор цаашид гэр оронгүй иргэдтэй холбоотой асуудлаар албан болон захиргааны статистик хөтлөх нөөц боломжийг олж харах, iii) нийгэмд харьцангуйгаар “орхигдсон” гэж болох бүлэг иргэдийн зарим асуудлыг бодлого, шийдвэр гаргагчдын анхааралд хүргэж, зорилтот үйл ажиллагаа явуулахад нь хувь нэмрээ оруулах зэрэг болно.

## 2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

### 2.1. “Гэр оронгүй хүн” -ийг тодорхойлох нь

Гэр оронгүй иргэдийн талаарх нэгдмэл нарийвчилсан ойлголт, тодорхойлолтгүйгээр асуудлыг судлах, шийдвэрлэх, иргэдийг гэр оронгүй, тэнэмэл болохоос урьдчилан сэргийлэх боломжгүй юм. “Гэр оронгүй байх” гэдгийг тодорхойлсон нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт Монгол Улс төдийгүй дэлхийн олон оронд ховор байна. Олон улсын тайлан судалгаануудаас харахад Нэгдсэн үндэстний байгууллага бий болсноос хойшхи 75 жилийн хугацаанд анх удаа гэр оронгүй иргэдийн асуудлыг 2020 онд НҮБ-ын 58-р Нийгмийн хөгжлийн комиссоор “Зохистой орон сууц болон гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн хамгааллын тогтолцоо” сэдвийн хүрээнд өргөнөөр хэлэлцсэн байна. Хурлаар “гэр оронгүй байх” гэдэг нь хүн зөвхөн орох оронгүй байхаар хязгаарлагдахгүй, гэр бүл, хамаатан садангүй, нийгмээс гадуурхагдан хүлээн зөвшөөрөгдөхөө болихыг хэлэх ба цаашилбал эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртэх, аюулгүй, хүн ёсны амьдрах боломжгүйд хүргэж буй тогтолцооны доголдол юм гэжээ. Олон улсад “гэр оронгүй байх” гэдгийг тодорхойлохдоо дараах байгууллагуудын тодорхойлсон ойлголт, зарчим, ангиллуудыг түгээмэл ашигладаг байна (АХБ & Когнос Интернейшнл, 2022). Үүнд:

1. Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэнгээс гаргасан тодорхойлолт<sup>5</sup>
2. Гэр оронгүйдэл болон орон байраар хангагдах эрх зөрчигдөхийг тодорхойлсон Европын тодорхойлолт (“ETHOS” гэж товчилдог) орно.

Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэнгээс гаргасан тодорхойлолт нь 6 тивийн 30 гаруй улсын судлаачид, бодлогын шинжээчид болон бодлого боловсруулагчдын хамтран боловсруулсан баримт бичиг юм. Тус баримт бичигт гэр оронгүй иргэдийг онцлог, шинж байдлаар нь гурван ерөнхий бүлгийн 17 нарийвчилсан ангилалд хуваан тодорхойлсон байна. Энэхүү хүрээлэнгээс гаргасан гэр оронгүй хүний талаарх ойлголт, тодорхойлолтуудыг хураангуйлан Хүснэгт 1-д гурван ерөнхий бүлгээр ангилан харуулав.

<sup>4</sup> Тоо мэдээллийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор улсын хэмжээнд тайлбарлах боломжгүй байв.

<sup>5</sup> Institute of Global Homelessness, Accessed on April 27, 2022, <https://ighomelessness.org/igh-announces-the-first-global-framework-on-homelessness/>

**Хүснэгт 1: Гэр оронгүй иргэний талаарх олон улсын тодорхойлолт**

Гэр оронгүй иргэн	Түр хоноглох төв болон эрсдэлт үед орогнох байранд амьдарч буй иргэн	Зохисгүй, аюулгүй бус орон сууцанд амьдарч буй иргэн
<p>1А. Гудамжинд эсхүл задгай газарт (цэцэрлэгт хүрээлэн, төмөр замын далан, гүүрний доор, замын хажуу, голын эрэг, ой мод гэх мэт) хонож буй иргэн</p> <p>1Б. Хүн амьдрах зориулалтын бус газарт (автобус болон вагоны буудал, таксины зогсоол, эзэнгүй барилга, нийтийн барилга, байгууламж гэх мэт) хонож буй иргэн</p> <p>1В. Автомашин, хүн тэрэг, завь, бусад тээврийн хэрэгсэлд хонож буй иргэн</p> <p>1Г. “Гудамж цэвэрлэгч” буюу оромж барьж, нэг цэгт тогтмол амьдардаг иргэн, өрх айл</p>	<p>2А. Түр хоноглох байранд хонож буй иргэн (орой бүр унтах газраа хайж олно)</p> <p>2Б. Гэр оронгүй иргэдэд зориулсан төв болон бусад түр хоноглуулах төвд амьдарч буй иргэн (өрөө, ор хуваарилж өгдөг)</p> <p>2В. Гэр бүлийн хүчирхийллээс зугтан түр хамгаалах байранд байгаа хүн</p> <p>2Г. Дотооддоо шилжин суурьшсан иргэдэд зориулсан хуаранд байрлаж буй зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг, хүнээс үүдэлтэй гамшиг, хүний эрхийн зөрчил, хөгжлийн гэх мэт шалтгааны улмаас орон гэрээсээ дайжсан, ингэхдээ хил даваагүй дотооддоо оршин сууж буй иргэн</p> <p>2Д. Орогнол хүсэгчид, дүрвэгсэд болон цагаач иргэдийг хүлээн авах хуаран болон хүлээн авах/ түр байрлуулах төвд байгаа иргэн</p>	<p>3А. Түр хугацаанд найз нөхөд, ах дүү, хамаатан садангийнхаа гэрт амьдарч буй иргэн</p> <p>3Б. Хүчирхийлэлд өртөх эрсэлд амьдарч буй иргэн</p> <p>3В. Хямд зочид буудал, дэн буудалд амьдарч буй иргэн</p> <p>3Г. Хүн амьдрах зориулалтын бус сууцанд шахцалдан амьдарч буй иргэн</p> <p>3Д. Хүн амьдрах зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэн</p> <p>3Е. Чиргүүл, майханд амьдарч буй иргэн</p> <p>3Ё. Хэт олуулаа амьдарч буй иргэн</p> <p>3Ж. Хүн амьдрах зориулалтын бус сууц, түр зуурын зориулалттай барилга байгууламж, ядуусын хороолол болон албан бус сууцанд амьдарч буй иргэн</p>

Эх сурвалж: Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн, 2017 он. (АХБ, Когнос ХХК, 2022-т эшлэсэнээр)

Монгол Улсын хувьд зарим хууль, тогтоомжид тухайлбал *Үндсэн хуулийн* 16.2-р зүйлд “Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах... эрхтэй” гэж заасан, мөн *Нийгмийн халамжийн тухай хууль*, *Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай* Засгийн Газрын 2014/04/26-ны өдрийн 137 дугаар тогтоол зэрэгт олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэнийг хамруулан зарим төрлийн үйлчилгээ үзүүлэх талаар заасан байна. Гэхдээ эдгээр хууль, тогтоомжид гэр оронгүй, тэнэмэл иргэд гэдэгт чухам хэнийг хамруулах талаарх нарийвчилсан тодорхойлолт байхгүй, зөвхөн тэнэмэл иргэдээр “гэр оронгүй иргэд”-ийг хязгаарласан, олон улсын тодорхойлолтоор “гэр оронгүй” гэсэн ангилалд багтах зарим анхаарал татсан бүлгийг, тухайлбал орцны жижүүр хийн орон сууцны орц, 00 өрөө, подваль зэрэг хүн амьдрах зориулалтын бус газарт амьдарч буй иргэдийг хамруулаагүй байна.

**2.2. Тоо мэдээлэл ба эмпирик судалгаа**

Дэлхий дахинаа 100 сая хүн гэр оронгүй, 1.6 тэбрум хүн зориулалтын бус сууцанд амьдарч байгаа (UN-HABITAT, 2005) гэсэн бүдүүвчилсэн статистик 2000-аад оны эхээр гарч байсан ба түүнээс хойш гэр оронгүй иргэдийн талаарх олон улсыг хамруулсан цэгцтэй тоо мэдээлэл ховор хэвээр байна. Гэр оронгүй иргэдтэй холбоотой албан статистик, судалгаанууд өндөр хөгжилтэй цөөн оронд харьцангуй жигдэрч чадсан байна. Тэдгээрт гэр оронгүй иргэдийг хамруулсан тооллого, судалгааг тогтмол давтамжтайгаар хийж, статистик мэдээллийг бүрдүүлж чадсан ба ард иргэдийн дунд ч судалгаа явуулж ойлголт, хандлагыг нь тодорхойлсон байдаг. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсад хийгдсэн судалгаанаас харахад, гэр оронгүйдлийн шалтгааныг ард иргэд олон хүчин зүйлээс хамаардаг гэж үнэлдэг ч дийлэнх нь “архины хэт хэрэглээ, мансууруулах бодист донтолтоос болж гэр оронгүй болдог” гэж үзэн буруутгах хандлагатай байдаг (Agans, R., Liu, G., Jones, M., Verjan, C., Silverbush, M., & Kalsbeek, W., 2015) байна (Хүснэгт 2).

**Хүснэгт 2: АНУ дахь иргэдийн гэр оронгүйдлийн шалтгаан, олон нийтийн үзэл бодлоор**

№	Гэр оронгүй болсон шалтгаан	%	95% CI*
1	архи, мансууруулах бодисын донтолт	91	88-94
2	сэтгэцийн өвчтэй	85	82-89
3	төлбөрийн чадварт нийцэх орон байрны боломж хомс	84	81-87
4	сэтгэцийн эмнэлгээс суллагдсан явдал	76	72-81
5	баячуудын илүүд үздэг эдийн засгийн тогтолцоо	74	70-78
6	засгийн газрын тусламж дутагдалтай	71	67-74
7	хөгжлийн бэрхшээлтэй	71	67-76
8	хариуцлагагүй зан үйл	71	67-75
9	залхуурал	62	57-66
10	сайн сургууль улсаас хангадаггүй	35	30-40
11	муу хувь заяа	53	48-57

\* Энэ нь итгэх интервалыг харуулна.

Эх сурвалж: Agans, R., Liu, G., Jones, M., Verjan, C., Silverbush, M., Kalsbeek, W., (2015). Public Attitudes Toward the Homeless.

Гэр оронгүйдлийн асуудлыг олон талаас нь судалсан судлаачдын дүгнэлтээр, аливаа хүн гэр оронгүй болоход хувь хүн, гэр бүлийн түвшний хүчин зүйлсээс гадна нийгэм, эдийн засгийн тогтолцооны хүчин зүйл ч нөлөөлдөг байна (Suzanne, 2020). Тухайлбал, хувийн болон гэр бүлийн улбаатай шалтгаанд сэтгэцийн эрүүл мэнд, гэр бүлийн хүчирхийлэл, мансууруулах бодисын зохисгүй хэрэглээ, архаг эсвэл эдгэшгүй өвчин болоод эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, даатгалд хамрагдах боломж дутмаг байдал, хөгжлийн бэрхшээл, гэр бүл салалт, хүүхдийн хүчирхийлэл зэрэг хамаардаг (Carol, A., Christopher, A., Magee, & Peter, J.K., 2016; Charlotte Fry et al., 2017). Харин тогтолцооноос хамааралтай гэр оронгүйдлийн шалтгаанд нийгэм дэх ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдэл болон бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны тогтворгүй байдал, ялгаварлан гадуурхалт, нийгмийн гадуурхалт, халамж асрамжийн газар болон эмзэг бүлгийн хүүхдэд зориулсан асран хамгаалах төвөөр үйлчлүүлэх насны болон бусад хязгаарлалт, орон сууцны хомсдол, орон сууцны хувьчлал, албадан нүүлгэн шилжүүлэлт, хотжилт, хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн, газар эзэмших боломжийн хязгаарлалт, байгалийн гамшгийн улмаас шилжин нүүх шаардлага болон зөрчилдөөн, мөргөлдөөн зэрэг хамаарна (Mabhala, M.A., Basma, Ellahi., Alan, M., & Paul, K., 2016).

Монгол Улсад гэр оронгүй иргэдийг цэгцтэй судалж бүртгэсэн дэлгэрэнгүй тоо, мэдээллийн сан өнөөг болтол албан ёсны статистикуудаар байхгүй<sup>6</sup> бөгөөд захиргааны шугамаар албан хэрэгцээнд байгаа тоо мэдээллүүд нь хоорондоо зөрүүтэй, нийтэд мэдээлэгддэггүй явсаар иржээ. Тоо мэдээлэл, судалгааны ажил дутмаг тул гэр оронгүйдлийн асуудлыг хөндсөн бодлого, хөтөлбөр, даацтай арга хэмжээнүүд ч дутагдалтай байна. Ялангуяа гэр оронгүйдэлд өртсөн өрх, иргэд ямар шинж байдалтай, яагаад ийм нөхцөлд амьдрах болсон талаар болон нөхцөл байдал, асуудал, бэрхшээлүүдийг нь ул үндэстэйгээр судлан, зохион байгуулалттайгаар бүгдийг хамруулсан арга хэмжээ авах ажил өнөөг хүртэл хийгдэхгүй байсаар байна (ХНХЯ, 2010). ХНХЯ-ны захиалгаар 2010 онд хийгдсэн орон сууцны орц, шатны хонгилд амьдарч буй “орцны жижүүр, цэвэрлэгч” иргэдийн судалгаагаар, нийт 1,204 орцны жижүүр хамрагдсанаас тал хувь нь гэр оронгүй, тэнэмэл иргэд байжээ. Түүнчлэн Монгол Улсад хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлаар хийгдсэн томоохон түүвэртэй судалгаануудаас харахад нийслэлд шилжин ирэгч дийлэнх иргэдэд суурьших газар олдохгүй, байр, хашаа худалдан авах санхүү хүрэлцэхгүй, нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх зэрэг асуудлууд тулгардгаас гадна эдийн засгийн чадавх болон боловсрол, мэргэжлийн байдал доогуур, мэдээлэл, тусламж олж авах танилын хүрээ хязгаарлагдмал байдгаас ажилд орох боломж муу, аргагүйн эрхэнд хүн амьдрах шаардлага, нөхцөл бүрдээгүй газарт ажиллаж, амьдардаг зэрэг үр дүнгүүд гарсан

<sup>6</sup> Зөвхөн 10 жилд нэг удаа хийгддэг Хүн ам, орон сууцны тооллогоор л “зориулалтын бус сууцанд амьдардаг өрх”-ийн тоо гэсэн нийт тоо гарч байна.

байдаг (ХНХЯ, ХАССТ, НҮБХАС, 2001; ХАССТ, НХХЯ, НҮБХАС, 2004; ҮСГ, НҮБХАС, 2007; ЭМШУИС, НҮБХАС, Япон Улсын Засгийн газар, 2007; НХХЯ, ХАССТ, НҮБХАС, 2009; ИОМ, SDC, UNU-MERIT, PTRC, 2018; ХАССТ, НҮБ-ын МИТЭЗНСХ, ОУШХБ, 2021; ОУШХБ, IRIM, 2021). Иймээс цаашид гэр оронгүй тэнэмэл иргэд болон зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн тоо мэдээллийг цэгцлэх, асуудлыг нарийвчлан судалж, тодорхой бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

### 3. АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ хоёрдогч мэдээллийн эх үүсвэрүүдийг ашигласан. Тодруулбал, Монгол Улсын болон Улаанбаатар хотын “гэр оронгүй иргэд”-ийн тоо хэмжээг олон улсын ойлголтын хүрээнд тогтоохдоо Үндэсний Статистикийн Хорооны Хүн ам, орон сууцны тооллого (ХАОСТ) болон Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төв, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс зэрэг захиргааны байгууллагын дотоод статистик мэдээллийг ашигласан. Харин гэр оронгүй иргэдийн шинж байдал, гэр оронгүйдлийн шалтгааныг тогтоохдоо Азийн хөгжлийн банкны захиалга, санхүүжилтээр Когнос интернэйшнл ХХК-ий 2022 онд хийсэн “Улаанбаатар хотын гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг үнэлэх” түргэвчилсэн судалгааны хүрээнд бий болсон тоон мэдээллийн бааз болон чанарын судалгааны мэдээллүүдийг ашигласан. Ингэхдээ тухайн судалгааны анхны тайланд ороогүй тоон шинжилгээ хийж, чанарын судалгааны мэдээллүүдийг нэмэлтээр хэрэглэсэн.

Арга зүйн хувьд, баримт бичгийн судалгааны арга, хоёрдогч мэдээлэлд “дүрслэх статистик”-ийн шинжилгээ хийх, ганцаарчилсан гүнзгийрүүлсэн ярилцлага болон түлхүүр мэдээлэгчтэй хийсэн ярилцлагын мэдээллүүдийг агуулгаар нь “сэдэвчлэн шинжлэх” зэрэг аргуудыг ашигласан.

Когнос интернэйшнл ХХК-ий судалгаанд **гэр оронгүй иргэн** гэдэгт 18 болон түүнээс дээш насны, тэнэмэл байдлаар, эсхүл орон сууцны орц, 00 өрөө, хонгил гэх мэт зориулалтын бус газарт амьдарч буй хүнийг хамруулсан ба дотор нь i) гэр оронгүй, тэнэмэл иргэд (ГОТИ), ii) гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд (ГОЗБСАИ) гэж хоёр бүлэгт хуваан судалсан байна<sup>7</sup>. Тоон судалгааны түүврийг магадлалт бус цасан бөмбөлгийн түүврийн загвараар бүрдүүлсэн<sup>8</sup> ба тэнэмэл иргэдээс 405 хүн<sup>9</sup>, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдээс 200 хүнийг хамруулсан байна.

### 4. ҮР ДҮН

#### 4.1. Монгол Улс дахь гэр оронгүй иргэдийн тоо хэмжээ

Олон улсын ойлголт, хандлагад суурилсан байдлаар гэр оронгүй иргэдийг тодорхойлбол тэнэмэл иргэдээс гадна хүн амьдрах зориулалтын бус газар, тухайлбал нийтийн орон сууцны орц, 00 өрөө, хонгилд амьдарч буй, мөн түр хугацаанд найз нөхөд, хамаатан садангийнхаа гэрт амьдарч буй иргэдийг хамруулдаг. Энэхүү ойлголтын хүрээнд Монгол Улс дахь өөрийн гэсэн гэр оронгүй иргэдийн тоог тогтоох боломжийг 2010 болон 2020 онд ҮСХ-оос хийсэн ХАОСТ-ууд олгож байна.

<sup>7</sup> Судалгааны түүвэрт Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийг сонгон мэдээлэл цуглуулсан байна.

<sup>8</sup> Гэр оронгүй иргэдийн нэгдсэн бүртгэл, статистик байхгүй тул түүврийг магадлалт бус загвараар бүрдүүлсэн ба Монгол Улсын хэмжээнд байгаа нийт гэр оронгүй иргэдийг бүрэн төлөөлөхгүй.

<sup>9</sup> Улсаас үйл ажиллагааг хариуцан ажиллуулдаг Нийгмийн хамгааллын тусгай төв, ТББ-ууд үйл ажиллагааг нь хариуцдаг Түр хоноглох байруудад хүйтний улиралд байрлаж байгаа гэр оронгүй 305 иргэн (А1 Бүлэг), мөн гудамжинд хэсүүчлэн хоноглож буй 100 иргэн (А2 бүлэг)-ийг хамруулсан. Гэхдээ олон улсад гэр оронгүй иргэнд тооцдог гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан түр хамгаалах байр, өндөр настны болон өнчин хүүхдийн асрамжийн газарт байрлаж буй иргэдийг цаг хугацаа, нөөц хязгаарлагдмал байсны улмаас хамруулж чадаагүй байна.

Дээрх тооллогуудаар өрхүүдийн сууцны төрөл, амьдарч буй сууцны эзэмшлийн талаар мэдээлэл цуглуулсан ба 2010 оны тооллогын тайлангаар “Зориулалтын бус сууц”, 2020 оны тооллогын тайлангаар “Бусад сууц”-нд амьдардаг өрхүүдийн тоо гэсэн статистикуудыг гаргасан байна. Эдгээр үзүүлэлтийн тайлбар, нарийвчилсан тодорхойлолтуудыг харвал нэгэн ижил агуулгатай байсан ба дараах төрлийн сууцуудыг багтаажээ. Үүнд: хүн амьдрах зориулалтгүй ч тооллогын үед хүн амьдарч байсан бүх төрлийн сууц, тухайлбал сургууль, үйлдвэр, албан газар, байгууллагын өрөө тасалгаа, байнгын бус түр орогнуулах байр, вагончик, амбаар, пин, агуулах, дэлгүүр мухлаг, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний худаг (траншей), ой мод, уул хад, агуй, задгай газар/талбай гэх мэт багтсан байна (ҮСХб, 2011; ҮСХ, 2020). Эдгээр нь “гэр оронгүй хүн”-ийг тодорхойлдог олон улсын ойлголт, тодорхойлолтод багтсан сууцны төрлүүд тул тооллогоор мэдээлсэн “бусад сууц/зориулалтын бус сууц”-анд амьдарч буйгаар тоологдсон өрх, хүн амыг “гэр оронгүй” гэсэн бүлэгт хамруулж болохоор байна.

ХАОСТ-оор 2020 оны Монгол Улсын нийт өрхийн 0.9 хувь буюу 8,039 өрх, Улаанбаатарын өрхүүдийн 0.5 хувь буюу 2,227 өрх “хүн амьдрах зориулалтгүй сууц”-нд амьдарч байгаа үр дүн гарсан байна (Хүснэгт 3). Эдгээр хүмүүс дээр өөрийн эзэмшлийн сууцгүй, бусдын сууцанд түрээс төлөх, эсвэл түрээс төлөхгүйгээр амьдарч буй өрхүүдийг нэмбэл, улсын хэмжээнд нийт өрхийн 8.4 хувь (74.8 мянган өрх), Улаанбаатар хотын хэмжээнд 10.3 хувь (42.3 мянган өрх) нь өөрийн эзэмшлийн гэр оронгүй гэж тоологдсон нь ихээхэн анхаарал татаж байна. Мөн олон улсын ойлголт, хандлагаар гэр оронгүй гэж тодорхойлж болох Монгол Улсын өрх, хүн амын дийлэнх нь нийслэлд байгааг анхаарахгүй орхиж болохгүй. 2020 оны тооллогын дүнг 2010 оныхтой харьцуулбал зориулалтын бус сууцанд амьдарч буй, мөн өөрийн эзэмшлийн сууцгүй амьдарч буй өрхийн биет тоо буурсан сайн тал байгаа ч хүн амын дунд “далд” гэр оронгүйдэл байсаар, тэдэнд чиглэсэн дорвитой арга хэмжээ, үр дүн байхгүй байсаар байна.

### Хүснэгт 3: Монгол Улс ба Улаанбаатар хотын өрхүүдийн хувь, амьдарч буй сууцны төрлөөр, сууцны эзэмшлээр, ХАОСТ-оор, 2010, 2020 он

Үзүүлэлтүүд	2010		2020	
	Улсын дүн	Улаанбаатар	Улсын дүн	Улаанбаатар
<b>Сууцны төрөл:</b>				
Гэр	45.3	28.9	38.2	22.2
Байшин	53.6	69.7	60.9	77.3
Орон сууцны байшин	(21.3)	n/a	(29.4)	n/a
Бие даасан тохилог сууц	(0.5)	n/a	(0.7)	n/a
Сууцны тусдаа байшин	(29.5)	n/a	(29.9)	n/a
Нийтийн байр	(2.3)	n/a	(0.9)	n/a
<b>Бусад (Зориулалтын бус сууц)</b>	<b>1.1</b>	<b>1.4</b>	<b>0.9</b>	<b>0.5</b>
	<b>(8,136 өрх)</b>	<b>(4,109)</b>	<b>(8,039 өрх)</b>	<b>(2,227 өрх)</b>
<b>Сууцны эзэмшлийн хэлбэр:</b>				
Өөрийн эзэмшлийн	86.7	81.7	91.6	89.7
Бусдын сууцанд түрээстэй	6.3	10.3	3.7	n/a
Бусдын сууцанд түрээсгүй	6.1	7.0	4.4	n/a
Бусад	0.9	0.9	0.3	n/a
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Нийт өрхийн тоо</b>	<b>713,780</b>	<b>302,242</b>	<b>897,427</b>	<b>411,420</b>

n/a- мэдээлэл байхгүй. Эх сурвалж: (ҮСХ, 2020; ҮСХа, 2011; ҮСХб, 2011)

Харин захиргааны мэдээллүүдийг авч үзвэл (Хүснэгт 4), Улаанбаатар хотод 2022 оны байдлаар 6,779 өрх зориулалтын бус сууц болон орчин үеийн сууцны шаардлага хангаагүй нийтийн байранд<sup>10</sup> амьдарч байгаа ба хэрэв нэг өрх дунджаар 3.6 гишүүнтэй гэж үзвэл 24,405 иргэн стандартын шаардлага хангасан гэр оронгүй байна гэсэн мэдээлэл байв. Дээрх өрхүүдээс 1,857 нь орон сууцны орц, подваль, 00 өрөөнд гэр бүлийн хамт байрлан амьдарч байна.

<sup>10</sup> Жишээ нь, төвлөрсөн ус, ариун цэврийн байгууламжид холбогдоогүй.

**Хүснэгт 4: Улаанбаатар хотод зориулалтын бус болон нийтийн зориулалттай байранд амьдарч буй өрхийн тоо, дүүргээр, захиргааны эх үүсвэрийн мэдээллээр, 2022 он**


Дүүрэг	Орцны жижүүр	Подвальд амьдарч буй иргэд, өрх	00-ын өрөөнд амьдарч буй иргэд, өрх	Нийтийн байранд амьдарч буй иргэд, өрх	Нийт
Баянгол	268	85	204	2177	<b>2,734</b>
Багануур	n/a	3	3	3	<b>9</b>
Налайх	n/a	3	n/a	n/a	<b>3</b>
Сүхбаатар	78	143	16	193	<b>4,30</b>
Баянзүрх	186	212	41	302	<b>741</b>
Багахангай	n/a	n/a	n/a	1	<b>1</b>
Хан-Уул	35	119	56	143	<b>353</b>
Сонгинохайрхан	147	67	52	1985	<b>2,251</b>
Чингэлтэй	14	7	118	118	<b>257</b>
<b>Нийт</b>	<b>728</b>	<b>639</b>	<b>490</b>	<b>4,922</b>	<b>6,779</b>

n/a- мэдээлэл байхгүй. Эх сурвалж: (НЗДТГ, Нийгмийн бодлогын хэлтэс, 2022)

Дээрхээс гадна сүүлийн таван жилийн хугацаанд “тэнэмэл” байдлаар хэсүүчлэн амьдарч буй гэр оронгүй иргэдийн талаар нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудаас хэд хэдэн статистик гаргасан байна. Тухайлбал, Нийслэлийн Нийгмийн халамжийн хэлтсийн судалгаагаар 2018 онд нийслэлд гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдарч буй 1,375 иргэн бүртгэгдсэн ба тэдний 79 хувь нь эрэгтэй; 52 хувь нь 18-45 насныхан, 40 хувь нь 46-59 насныхан; тал хувь нь 5-аас дээш жил тэнэмэл байдлаар хэсүүчлэн амьдарч буйг тогтоосон байна. Шилжилт хөдөлгөөний байдлаар харвал, 80 хувь нь Улаанбаатар хотын уугуул, 20 хувь нь хөдөө орон нутгаас шилжин ирсэн иргэд байжээ (АХБ, 2019).

COVID-19 цар тахлын үеэр улс даяар хэрэгжүүлсэн хөл хорионы хүрээнд Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төв, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран орон гэргүй, тэнэмэл амьдралтай, архины хамааралтай иргэдийн бүртгэл судалгааг 2020 оны 12 дугаар сарын байдлаар гаргасан ба нийт 850 иргэнийг олж тогтоон мэдээллийн сан үүсгэсэн байна. Эдгээр байгууллагын тусламжтайгаар Нийгмийн хамгааллын тусгай төв<sup>11</sup>-д цар тахлын үеэр харьцангуй олон гэр оронгүй тэнэмэл иргэд байрлан үйлчилгээ авсан байна. Цар тахлаас хойших байдлыг харвал, 2023 он гэхэд Нийгмийн хамгааллын тусгай төвөөр 781 тэнэмэл иргэн үйлчлүүлсний 525 нь өмнө ирж байсан, 256 нь шинээр гэр оронгүй болсон иргэд байв (Зураг 1).

**Зураг 1: Нийгмийн хамгааллын тусгай төвөөр үйлчлүүлсэн ГОТИ-ийн тоо, өмнө үйлчлүүлж байсан эсэхээр, 2015-2023 он**



Эх үүсвэр: Нийгмийн хамгааллын тусгай төв (2024).


<sup>11</sup> Гэр оронгүй тэнэмэл иргэдийг хүйтний улиралд түр байрлуулан, суурь хэрэгцээг хангах үйлчилгээ үзүүлдэг улсын байгууллага.



## 4.2. Гэр оронгүй иргэдийн шинж байдал

Улаанбаатарт байгаа гэр оронгүй иргэдийн шинж байдлыг ГОТИ болон ГОЗБСАИ-ийн хувьд тусдаа судалсан. Гэр оронгүй иргэдийн нас, хүйсийн бүтцийг дүрсэлсэн Зураг 2-оос харахад, тэнэмэл байдлаар амьдарч буй гэр оронгүй 8 хүн тутмын 7 нь эрэгтэй байгаа бол зориулалтын бус сууцанд амьдарч буй 3 хүн тутмын 2 нь эмэгтэй байна. Насны хувьд гэр оронгүй тэнэмэл иргэд ба зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд онцлох зөрүүгүй, дунджаар 46.4-48.3 настай хүмүүс байна.

**Зураг 2: Улаанбаатар дахь гэр оронгүй иргэдийн хувь, нас, хүйсээр**



Эх сурвалж: АХБ, Когнос интернэйшл ХХК (2022)-ийн мэдээлэлд үндэслэсэн тооцоо.


Боловсролын байдлыг харвал, хоёр бүлгийн иргэд төстэй байсан ба боловсролгүй хүн амын хувь ГОТИ-ийн дунд улсын дунджаарх ижил үзүүлэлтээс 1.8 дахин, ГОЗБСАИ-ийн дунд 1.6 дахин их, харин дээд боловсролтой хүн амын хувь нь улсын дунджаас харгалзан 2.3 ба 3.1 дахин бага байв<sup>12</sup>.

Мөн гэр оронгүй амьдарч байгаа иргэдийн дундах гэр бүл салсан, цуцалсан, бэлэвсэн иргэдийн хувийн жин улсын дунджаас харьцангуй өндөр байна<sup>13</sup>. Ялангуяа ГОТИ-ийн хувьд 5 хүн тутмын 3 нь гэр бүл салсан, бэлэвсэн, ГОЗБСАИ-ийн хувьд 3 хүн тутмын 2 нь баталгаагүй гэр бүл буюу хамтран амьдрагчтай, гэр бүл салсан, бэлэвсэн хүмүүс байгаа нь гэр оронгүй иргэдийн нэг онцлог шинж болж байна (Зураг 3).

<sup>12</sup> ХАОСТ-2020-оор, улсын дүнгээр 10, түүнээс дээш настай нийт хүн амын 13.7 хувь нь бага, 17.1 хувь суурь, 29.2 хувь бүрэн дунд, 8.6 хувь техникийн болон тусгай мэргэжлийн, 24.2 хувь дипломын болон бакалаврын дээд, 2.1 хувь магистр, 0.1 хувь докторын түвшний боловсролтой байна.

<sup>13</sup> ХАОСТ-2020-оор, Монгол Улсын арван тав, түүнээс дээш насны хүн хүн амын 31.5 хувь нь огт гэр бүл болоогүй, 60.6 хувь гэрлэсэн, 2.4 хувь цуцалсан/тусгаарласан, 5.5 хувь бэлэвсэн байна.

**Зураг 3: Улаанбаатар дахь гэр оронгүй иргэдийн хувь, гэрлэлтийн байдлаар**




Эх сурвалж: АХБ, Когнос интернэйшл ХХК (2022)-ийн мэдээлэлд үндэслэсэн тооцоо.

Шилжих хөдөлгөөнд оролцсон байдлыг харвал ГОТИ-ийн хувьд талаас илүү нь, ГОЗБСАИ-ийн хувьд 3 хүн тутмын 2 нь Улаанбаатарын унаган биш иргэд буюу сүүлийн 10 гаруй жил дотор орон нутгаас шилжин ирэгчид байгаа нь анхаарал татаж байв.

Гэр оронгүйдэлд өртсөн иргэд хэр удаан гэр оронгүй амьдарч буй хугацааг тооцон харвал, ГОТИ-ийн хувьд дунджаар 9.8 жил, ГОЗБСАИ-ийн хувьд дунджаар 7.6 жил байгаа нь гэр оронгүйдлийн асуудал Монгол Улсад ужгирсан асуудал болсоныг харуулж байна (Зураг 4). Түүнчлэн боловсрол доогуур, гэр бүл салсан юмуу бэлэвсэн, ахимаг настай хүмүүс гэр оронгүй амьдралаар илүү удаан амьдарч буй нь харагдлаа.

**Зураг 4: Гэр оронгүй амьдарч буй хугацааны медиан (жил) үзүүлэлт, хүн ам зүйн шинж байдлаар**



Эх сурвалж: АХБ, Когнос интернэйшл ХХК (2022)-ийн мэдээлэлд үндэслэсэн тооцоо.

### 4.3. Гэр оронгүйдлийн шалтгаан

АХБ, Когнос интернэйшл ХХК (2022)-ий судалгаагаар Улаанбаатар дахь иргэдийн гэр оронгүйдлийн шалтгааны талаарх мэдээллийг тоон ба чанарын судалгааны аргуудаар нэлээн өргөн хүрээнд цуглуулсан ч судалгааны үндсэн тайланд маш товч байдлаар тусгагдсан юм. Иймд энэхүү өгүүлээр тоон судалгаагаар цуглуулсан гэр оронгүйдлийн шалтгааны мэдээллийг судалгаанд оролцогчдын шинж байдлаар задлан дэлгэрүүлж судлахын зэрэгцээ чанарын судалгаагаар цуглуулсан ч үндсэн тайланд тусгагдаагүй зарим мэдээллийг танилцуулав.

Судалгаанд оролцсон гэр оронгүй иргэдэд “Та яагаад гэр оронгүй болсон бэ?” гэсэн асуултыг тавихад ГОТИ-ийн хувьд i) архинд донтож гэрээсээ хөөгдсөн/явсан, ii) гэр бүл салсан, iii) гэр бүл дэх хүчирхийллээс дайжсан юмуу гадуурхагдаж хөөгдсөн зэрэг шалтгаанууд тэнэмэл амьдрал руу орох тэргүүлэх шалтгаанууд болсон нь харагдлаа. Харин ГОЗБСАИ-ийн хувьд i) орон нутгаас шилжин ирээд амьдрах газар/байр олдоогүй, ii) орон байртай болох хангалттай орлого, мөнгөгүй, iii) гэр бүл салсан гэсэн шалтгаанууд эхний гурван гол шалтгаан болж эрэмбэлэгдсэн байна (Хүснэгт 5, Шигтгээ 1, Шигтгээ 2).

#### Хүснэгт 5: Гэр оронгүй иргэдийн хувь, гэр оронгүйдлийн шалтгаанаа нэрлэснээр\*, судалгаанд оролцогчдын бүлгээр

Гэр оронгүй амьдрах болсон шалтгаан	ГОТИ	Гэр оронгүй амьдрах болсон шалтгаан	ГОЗБСАИ
Архинд донтож гэрээсээ хөөгдсөн /явсан	43.2	Орон нутгаас шилжин ирээд газар/ байр олдоогүй	45.0
Гэр бүл салсан	27.7	Хангалттай орлого, мөнгөгүй	38.0
Гэр бүл дэх хүчирхийллээс дайжсан/ гадуурхагдаж хөөгдсөн	23.7	Гэр бүл салсан	9.5
Хангалттай орлого, мөнгөгүй	11.6	Анхнаасаа орон гэр байгаагүй	7.0
Өөрөөсөө болсон / ажлаасаа гарсан /гэрээ зарсан	7.9	Гэр бүл дэх хүчирхийллээс дайжсан / гадуурхагдаж хөөгдсөн	6.0
Орон нутгаас шилжин ирээд газар/байр олдоогүй	7.4	Туслах танил тал байхгүй	6.0
Ойр дотны хүн нас барсан	7.2	Хүмүүст залилуулсан / өр зээлийн дарамт	5.0
Хүнд залилуулсан/ өр зээлийн дарамт	5.9	Байгалийн гамшигт өртсөн/гэр шатсан	4.5
Ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан	4.2	Өөрөөсөө болсон / ажлаасаа гарсан/ гэрээ зарсан	4.0
Туслах танил тал байхгүй	4.2	Үр хүүхэд, хамаатандаа гэрээ өгсөн	2.5
Байгалийн гамшигт өртсөн/гэр шатсан	4.0	Ойр дотны хүн нас барсан	1.5
Анхнаасаа гэр орон байгаагүй	3.7	Архинд донтож гэрээс хөөгдсөн /явсан	0.5
Үр хүүхэд, хамаатандаа гэрээ өгсөн	1.7	Ял шийтгэл эдэлсэн тул гадуурхагдсан	0.5
Бусад	5.4	Бусад	9.0
<b>Хариулагчдын тоо*</b>	<b>405</b>	<b>Хариулагчдын тоо*</b>	<b>200</b>

\*олон сонголттой асуулт тул хариутын нийлбэр 100 хувиас илүү.

Эх сурвалж: Улаанбаатар хотын гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг үнэлэх түргэвчилсэн судалгааны тайлан, Азийн хөгжлийн банк, Когнос интернэйшл ХХК, 2022

Эдгээрээс гадна ойр дотны хүн, асран хамгаалагчид нь нас барсан, ял шийтгэл эдэлж байгаад чөлөөлөгдсөн, гэр орон нь байгалийн гамшигт өртсөн, анхнаасаа гэр оронгүй буюу асрамжийн газарт өссөн бөгөөд туслах танил тал байхгүй зэрэг шалтгаанаар ГОТИ-ийн 23.3 хувь, ГОЗБСАИ-ийн 19.5 хувь нь гэр оронгүй амьдралд орсон байгаа нь тогтолцооны холбогдолтой хүчин зүйлс иргэдийн гэр оронгүйдэлд тодорхой хэмжээнд нөлөөлж буйг харуулж байна. Ялангуяа асрах газраас насанд хүрэн гарч буй иргэд, хорих газраас чөлөөлөгдөж буй иргэд, байгалийн гамшигт өртсөн иргэд зэрэг нийгмийн эмзэг бүлгүүд рүү чиглэсэн урт хугацааны гэр оронгүйдлээс урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа Монгол Улсад шаардлагатай нь харагдаж байна.

## Шигтгээ 1: Гэр оронгүйдлийн шалтгаан, гэр оронгүй иргэдийн тайлбараар

... Сөгтохоороо би ааш муутай, цалингаа буухаар нөхөртэйгээ нийлж байгаад л уучихдаг байсан. Гэхдээ нөхрийн дарамт, хадмуудын харилцаанаас л болсон. Хадмынх 4 гудамжны урд байдаг ч байнга л манай амьдралд оролцдог байлаа. Нөхрийн ах надтай цуг ажилладаг байсан, тухайн үедээ манай нөхөрт их худлаа ярьдаг, тэр үгэнд нөхөр их итгэнэ, тэгээд л хэрүүл болно. Орой 9 цагт нөхөр ирдэг, би цаг хараад л яах бол, юу ярьж орж ирэх бол гээд л айгаад сууж байдаг байсан. 1998 онд нөхөр над руу сүх шидээд тэгээд л шийдээд шууд зугтсан. Эмэгтэй хүн их дарамтлуулаад ирэхээр шийдвэр их хурдан гаргадаг юм билээ. 2 хоног яваад юм ч олж идээгүй, өлсөөд цангаад, орцонд хоносон. Цуки хаус, Брау хаус зэрэг газруудаар вип өрөө цэвэрлээд хоол унд, архины үлдээгдэл авчихдаг байсан. Өвөлдөө орцны жижүүр хийгээд, цалин буухаар хааяа хүнд мэдэгдэхгүйхэн архи уудаг...

Түр хоноглуулах байранд байрлаж буй ГОТИ, нас 48, эмэгтэй

... 1990 онд 8-р ангиа төгссөн, багаасаа аавыгаа дуурайгаад хөгжим тоглодог, айлын том, доороо 5 дүүтэй байсан. Хөдөөдөө байсан бол нилээн өндөр түвшинд л ажиллаж, амьдарч байх байсан байх. Хотод орж ирээд тогоочоор Да хүрээ захад ажилладаг байсан. Ууж идэж явсаар байгаад, хулгай хийдэг болсон. 1997 онд шоронд ороод гарч ирсэн. 2002 онд хүүхэдтэй болоод 2005 онд салсан. Хоёрдогч түүхий эд цуглуулж тушаагаад, заримдаа гуанз дэлгүүрийн талбайг цэвэрлээд архины мөнгөө олдог болсон. 2014 оноос хойш гадуур явж байна...

Түр хоноглуулах байранд байрлаж буй ГОТИ, нас 48, эрэгтэй

... 4 настайгаасаа хойд аавтай болсон. Бага нас их дарамтанд өссөн учраас 8 наснаасаа гадуур тэнэдэг болсон. 10 орчим хүүхэдтэй нийлээд тэнэж байгаад л оройдоо харьдаг байсан. Ээж ажилдаа явчихдаг, хойд аав архи уудаг, мөрийтэй тоглодог, золбин гэж дуудаад хүүхэд уйлууллаа гээд л зоддог байсан. Одоо ч ээж аав 2 намайг траншейных гээд л дууддаг. 2001 онд би нөхөртэйгээ суугад том охиноо, 2003 онд дунд охиноо гаргаад, нөхөртэйгээ муудалцаад очихоор л аав ээжид “чиний золбин охин 2 шээс дагуулаад ирлээ, амьдралд гай боллоо” гээд загнадаг байсан. Тэгээд томыгоо ээжид үлдээгээд нөгөө охиныг аав нь аваад, би хүнд гай болохгүй амьдаръя гээд л гудамжинд гарсан. Шууд гарчихаар очих газаргүй хүн чинь хаа саагүй л хоноглож, архины хамааралтай ч болсон. Хямдхан архи уугаагүй, өөрийнхөө олсон мөнгөөр ууж байна гэх мэтээр өөрийгөө өмөөрдөг байсан. 2008 оноос л жинхэнэ шуудай үүрээд гудамжинд явдаг, архины мөнгөө л олох гэж тэнээд л явдаг болсон....

Түр хоноглуулах байранд байрлаж буй ГОТИ, нас 40, эмэгтэй

## Шигтгээ 2: Гэр оронгүйдлийн шалтгаан, нийгмийн хамгааллын мэргэжилтний тайлбараар

... Хараад байхад, шилжин ирсэн хүмүүст хамгийн наад зах нь ирсний дараах хоёр жилийн хугацаанд маш том дэмжлэг яаралтай үзүүлэх хэрэгтэй байдаг юм билээ. Тэгж байж ирсэн хүмүүсийг хөлөө олоход нь туслаж, тэд маань ядууралд хүрэхгүй байх боломж нэмэгдэнэ гэж үзэж байгаа. Энэ нь тэднийг ядуу, орон гэргүй болчихоос сэргийлэх, орон гэргүй тэнэмэл хүмүүс нэмэгдэхгүй байх бас нэг нөхцөл нь болж өгнө. Боловсролгүй залуучууд ажиллаж байгаад ажилгүй болчихвол, тэгээд эцэг эх, ах дүү нар нь хотод байхгүй бол орон гэргүй болоод л явчихна. Гэр бүлээсээ саллаа, бас л орон гэргүй болоод явчихна. Ер нь ямар нэгэн том асуудал гарахад автоматаар орон гэргүйчүүдийн эгнээнд орчихно шүү дээ...

Олон улсын байгууллагад ажиллаж буй мэргэжилтэн

Дээрх бүгдээс дүгнэвэл, гэр оронгүйдэлд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь ГОТИ-ийн хувьд “хувь хүний болон гэр бүлийн хүрээллийн эрсдэлт зан үйл, хүчин зүйлс”-тэй холбоотой, харин ГОЗБСАИ-ийн хувьд орон нутгийн хөгжил, нийгмийн хүчин зүйлс зэрэг “тогтолцооны хүчин зүйлс”-тэй холбоотой байна.

Гэр оронгүйдлийн шалтгааныг хүйсээр задлан шинжлэхэд, эрэгтэйчүүдийн хувьд “архинд донтож гэрээсээ хөөгдсөн/явсан” гэх шалтгаан (47.3 хувь), харин эмэгтэйчүүдийн хувьд “гэр бүлийн хүчирхийллээс болж гэрээсээ зугтсан/хөөгдсөн” гэсэн шалтгаан (32.7 хувь) хамгийн их байна. ГОЗБСАИ-ийн хувьд “орон нутгаас шилжин ирээд амьдрах газар олдоогүй” гэсэн шалтгаан эмэгтэйчүүдийн хамгийн том шалтгаан (48.2 хувь), харин эрэгтэйчүүдийн хувьд “хангалттай орлого, мөнгөгүй” гэдэг шалтгаан тэргүүлэх шалтгаан (40.7 хувь) байсан байна (Хүснэгт 6).

**Хүснэгт 6: Гэр оронгүй иргэдийн хувь, гэр оронгүйдлийн шалтгаанаа нэрлэснээр\*, хүйсээр**

Таны орон гэргүй/зориулалтын бус сууцанд амьдрах болсон шалтгаан юунаас болж үүссэн бэ?	Гэр оронгүй, тэнэмэл иргэд /ГОТИ/			Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд /ГОЗБСАИ/		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Архинд донтож гэрээсээ хөөгдсөн /явсан	47.3	15.4	43.2	16.9	6.4	9.5
Гэр бүл салсан	28.3	23.1	27.7	5.1	6.4	6.0
Гэр бүл дэх хүчирхийллээс болж гэрээс дайжсан / гэртээ гадуурхагдаж хөөгдсөн	22.4	32.7	23.7	1.7	0.0	0.5
Орон нутгаас шилжин ирээд газар/байр олдоогүй	6.5	13.5	7.4	37.3	48.2	45.0
Хангалттай орлого, мөнгөгүй	11.3	13.5	11.6	40.7	36.9	38.0
Хүмүүст хууртаж, залилуулсан / өр зээлийн дарамт	5.9	5.8	5.9	6.8	4.3	5.0
Байгалийн гамшигт өртсөн / гэр шатсан	4.0	3.8	4.0	1.7	5.7	4.5
Ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан	4.8	0.0	4.2	0.0	0.7	0.5
Туслах танил тал байхгүй	4.2	3.8	4.2	8.5	5.0	6.0
Өөрөөсөө болсон / ажлаасаа гарсан	4.0	5.8	4.2	1.7	5.0	4.0
Гэрээ зарсан/ анхнаасаа орон гэр байгаагүй	3.7	3.8	3.7	10.2	5.7	7.0
Ойр дотны хүн нас барьсан	6.5	11.5	7.2	0.0	2.1	1.5
Үр хүүхэд болон хамаатан найздаа гэрээ өгсөн	1.7	1.9	1.7	3.4	2.1	2.5
Бусад	4.2	13.5	5.4	10.2	8.5	9.0

\*олон сонголттой асуулт тул хариутын нийлбэр 100 хувиас илүү.

Насны бүлгээр шинжлэхэд, ГОТИ-ийн хувьд аль ч насныхны дунд архины донтолттой холбоотой шалтгаан хамгийн том жин (36.3-48.6 хувь) эзэлж байна. Харин ГОЗБСАИ-ийн хувьд 35 хүртэлх, эсхүл 45-аас дээш насныхны хувьд “орон нутгаас шилжин ирээд амьдрах газар олдоогүй” гэсэн шалтгаан тэргүүлж байна (Хүснэгт 7).

**Хүснэгт 7: Гэр оронгүй иргэдийн хувь, гэр оронгүйдлийн шалтгаанаа нэрлэснээр\*, насаар**

Таны орон гэргүй/зориулалтын бус сууцанд амьдрах болсон шалтгаан юунаас болж үүссэн бэ?	Гэр оронгүй, тэнэмэл иргэд /ГОТИ/				Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд /ГОЗБСАИ/			
	19-35	36-45	46-55	56+	19-35	36-45	46-55	56+
Гэр бүл салсан	25.0	26.9	29.2	27.5	9.5	5.7	13.9	5.9
Гэр бүл дэх хүчирхийллээс болж гэрээс дайжсан / гэртээ гадуурхагдаж хөөгдсөн	32.5	26.9	25.0	14.7	0.0	2.9	11.1	5.9
Архинд донтож гэрээсээ хөөгдсөн /явсан	42.5	42.9	48.6	36.3	0.0	2.9	0.0	0.0
Орон нутгаас шилжин ирээд газар/байр олдоогүй	15.0	5.9	7.6	5.9	50.0	34.3	48.6	43.1
Хангалттай орлого, мөнгөгүй	17.5	9.2	9.7	14.7	42.9	40.0	41.7	27.5
Хүмүүст хууртаж, залилуулсан / өр зээлийн дарамт	2.5	4.2	4.9	10.8	0.0	2.9	8.3	5.9
Байгалийн гамшигт өртсөн / гэр шатсан	2.5	2.5	5.6	3.9	0.0	8.6	5.6	3.9
Ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан	2.5	3.4	5.6	3.9	0.0	0.0	0.0	2.0
Туслах танил тал байхгүй	2.5	7.6	2.1	3.9	9.5	8.6	4.2	3.9
Өөрөөсөө болсон / ажлаасаа гарсан	0.0	4.2	3.5	6.9	4.8	2.9	1.4	7.8
Гэрээ зарсан/ анхнаасаа орон гэр байгаагүй	5.0	5.0	2.1	3.9	9.5	14.3	0.0	9.8
Ойр дотны хүн нас барьсан	10.0	7.6	5.6	7.8	0.0	5.7	0.0	2.0
Үр хүүхэд болон хамаатан найздаа гэрээ өгсөн	0.0	2.5	1.4	2.0	0.0	0.0	0.0	9.8
Бусад	2.5	5.9	6.9	3.9	9.5	17.1	6.9	5.9

\*олон сонголттой асуулт тул хариутын нийлбэр 100 хувиас илүү.

Гэр оронгүйдлийн шалтгаан иргэдийн боловсролын түвшнээр ялгаатай байгаа эсэхийг шинжлэхэд, ГОТИ-ийн хувьд боловсролын ялгаанаас үл хамааран архинд донтож, гэрээсээ явсан шалтгаан голчилж байна. Харин ГОЗБСАИ-ийн хувьд мэргэжлийн боловсрол эзэмшээгүй буюу бүрэн дунд, түүнээс доош боловсролтой хүмүүсийн хувьд “орон нутгаас шилжин ирээд амьдрах газар олдоогүй” гэсэн шалтгаан голлож байна (Хүснэгт 8). Гэхдээ ямар нэгэн мэргэжил эзэмшсэн ГОЗБСАИ-ийн хувьд “орлого, мөнгөний хүрэлцээгүй байдал” нь гэр оронгүйдэлд өртөхөд нөлөөлсөн хамгийн том хүчин зүйл болж байгаа ажээ.

**Хүснэгт 8: Гэр оронгүй иргэдийн хувь, гэр оронгүйдлийн шалтгаанаа нэрлэснээр\*, боловсролын түвшнээр**

Таны орон гэргүй/зориулалтын бус сууцанд амьдрах болсон шалтгаан юунаас болж үүссэн бэ?	Гэр оронгүй, тэнэмэл иргэд /ГОТИ/				Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд /ГОЗБСАИ/			
	Боловсролгүй / Бага	Суурь	Бүрэн дунд	Мэргэжлийн/ дээд	Боловсролгүй / Бага	Суурь	Бүрэн дунд	Мэргэжлийн/ дээд
Архинд донтож гэрээсээ хөөгдсөн /явсан	37.9	41.3	50.0	37.9	0.0	0.0	0.0	2.4
Гэр бүл дэх хүчирхийллээс болж гэрээс дайжсан / гэртээ гадуурхагдаж хөөгдсөн	28.8	26.9	19.6	23.0	3.7	4.7	8.0	4.8
Гэр бүл салсан	28.8	23.1	30.4	27.6	11.1	9.3	6.8	14.3
Хангалттай орлого, мөнгөгүй	19.7	9.6	11.5	8.0	33.3	30.2	42.0	40.5
Орон нутгаас шилжин ирээд газар/байр олдоогүй	7.6	9.6	6.8	5.7	44.4	48.8	47.7	35.7
Ойр дотны хүн нас барьсан	9.1	9.6	4.1	8.0	3.7	2.3	1.1	0.0
Гэрээ зарсан/ анхнаасаа орон гэр байгаагүй	1.5	7.7	2.0	3.4	7.4	7.0	8.0	4.8
Хүмүүст хууртаж, залилуулсан / өр зээлийн дарамт	1.5	5.8	7.4	6.9	3.7	7.0	6.8	0.0
Байгалийн гамшигт өртсөн / гэр шатсан	0.0	5.8	5.4	2.3	7.4	2.3	5.7	2.4
Ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан	3.0	4.8	4.1	4.6	0.0	2.3	0.0	0.0
Туслах танил тал байхгүй	6.1	6.7	3.4	1.1	14.8	4.7	5.7	2.4
Бусад	6.1	2.9	4.7	9.2	11.1	11.6	8.0	7.1
Өөрөөсөө болсон / ажлаасаа гарсан	4.5	5.8	3.4	3.4	0.0	9.3	2.3	4.8
Үр хүүхэд болон хамаатан найздаа гэрээ өгсөн	0.0	1.9	2.0	2.3	7.4	7.0	0.0	0.0

\*олон сонголттой асуулт тул хариутын нийлбэр 100 хувиас илүү.

**5. Дүгнэлт, хэлэлцүүлэг**

Монгол Улсад гэр оронгүй хүмүүс гэхээр тэнэмэл иргэдийг ихэвчлэн төсөөлдөг ч олон улсын ойлголт, тодорхойлолтоор энэ нь илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт нийгмээс ардчилсан, чөлөөт зах зээлийн тогтолцоо бүхий нийгэм рүү шилжсэн үеэс хойш “тэнэмэл”, “траншейний” гэх мэт хүмүүсийн асуудал нийгэмд яригддаг болсон. Гэвч тэднээс өөр төрлийн буюу “далд” хэлбэртэй гэр оронгүйдлийн үзэгдэл нийгэмд аль хэдийн бий болж, олон өрх, хүн амыг хамран багагүй хугацаа өнгөрснийг төдийлөн анзаарахгүй явсаар ирсэн байна. “Далд” хэлбэртэй гэр оронгүйдлийн нэг төрөл нь хүн амьдрах зориулалтын бус сууцанд амьдарч буй өрх, иргэд юм. Шийдвэр гаргагчдын дунд тэдний талаарх ойлголт, албан тоо статистик, мэдээлэл, судалгаа ховор байгаагаас “Хэнийг ч хөгжлөөс үл орхих” гэдэг НҮБ-ын зарчим алдагдаж буйг гэр оронгүйчүүдийн асуудлыг судалдаг байгууллагууд онцолсоор байна.

Захиргааны эх үүсвэрийн мэдээллээр, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэд Улаанбаатарт сүүлийн 5 жилийн дунджаар 1000 гаруй бүртгэлтэй байгаа нь харьцангуй цөөн мэт боловч ХАОСТ-оор 2020 онд Монгол Улсын хувьд 8,039 өрх, Улаанбаатарт 2,227 өрх “хүн амьдрах зориулалтгүй сууц”-нд амьдарч байгаа гэж тоологдсон байна. Эдгээр хүмүүс дээр өөрийн эзэмшлийн сууцгүй, бусдын сууцанд түрээс төлж, эсвэл түрээс төлөхгүйгээр амьдарч буй өрхүүдийг нэмбэл, улсын хэмжээнд нийт 74.8 мянган өрх (нийт өрхийн 8.4 хувь), Улаанбаатар хотод 42.3 мянган өрх (нийт өрхийн 10.3 хувь) өөрийн эзэмшлийн гэр оронгүй гэж тоологдсон нь ихээхэн анхаарал татаж байна. Түүнчлэн тэнэмэл болон зориулалтын бус сууцанд амьдрах хэлбэрийн гэр оронгүйдэлд өртсөн иргэдийн судалгаагаар тэд дунджаар 8-10 жил гэр оронгүй амьдарч байгаа талаар мэдээлснээс харвал, гэр оронгүйдлийн үзэгдэл Монгол Улсад ужгирсан байна.

Нийгэмд гэр оронгүй хүмүүсийг ихэнхдээ “архины донтолтоос болж гэр оронгүй болдог” гэсэн нийтлэг ойлголт байдаг ч иргэдийн гэр оронгүйдлийн шалтгаан нь зөвхөн хувь хүний хүчин зүйлээс бус гэр бүл, тогтолцооны асуудлуудтай ч холбоотой байдгийг Улаанбаатарын жишээгээр хийсэн шинжилгээ харууллаа. Гэр оронгүйдлийн голлох шалтгаанууд дунд ГОТИ-ийн хувьд архины донтолт (ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд), гэр бүлийн тогтворгүй байдал,

гэр бүл дэх хүчирхийлэл (ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд) зэрэг хувь хүн, гэр бүлийн хүрээний тулгамдсан асуудлууд, харин ГОЗБСАИ-ийн хувьд хөдөө орон нутгаас шилжин ирээд “хөлөө олж чадаагүй” буюу орлогын боломжид нь тохирсон сууц олдохгүй, орлого, санхүү хүрээлцээгүй зэрэг тогтолцооны холбоотой шалтгаан ихээхэн жин эзэлж байна. Энэ нь олон улсын судалгаануудын үр дүнтэй төстэй байна. Эдгээрээс гадна ойр дотны хүн нас барах, асрах газарт амьдарч буй хүүхдүүд насанд хүрч асрамжийн газраас гарах, ял шийтгэл эдэлж байсан хүн чөлөөлөгдөн гарах зэрэг тохиолдлуудад тэднийг ялгаварлан гадуурхах, хөлөө олоход нь ойлгож, тусалж дэмжих хүрээлэл байхгүй байх зэрэг нь зарим иргэдийг гэр оронгүйдэлд өртөхөд нөлөөлсөн байгааг судалгааны үр дүн харуулсан. Эдгээрийг мөн “тогтолцооны” холбогдолтой хүчин зүйл гэж үзэж болох юм.

Дэлхийн банк (2012)-наас гаргасан судалгаагаар гэр оронгүй иргэдэд чиглэсэн улс орнуудын ихэнх үйлчилгээ асуудлаас урьдчилан сэргийлэхээс илүү гал унтраасан, ганц нэг төрлийн байгууллагад суурилсан тусламж үйлчилгээ хэлбэртэй байгааг тэмдэглэжээ. Зүй нь шийдвэр гаргагчид гэр оронгүй иргэдэд үзүүлж буй туслалцаа, үйлчилгээний доголдлоо тогтоож, хот төлөвлөлт, эрүүл мэнд, боловсрол, зам тээвэр, нийгмийн халамж, хуулийн болон хууль сахиулах зэрэг байгууллагуудын жигд оролцоог хангаж, “засгийн газар бүхэлдээ” хүчин чармайлт гаргах, гэр оронгүй иргэдтэй ажиллахад олон нийтийн оролцоог бий болгох шаардлагатайг онцолсон байдаг. Мөн тус судалгаагаар гэр оронгүй иргэдэд үзүүлэх тусламж нь асуудал, бүлгээсээ шалтгаалан холимог хэлбэрээр явагдах нь зүйтэйг дурьдсан. Тухайлбал, өвлийн улиралд тэнэмэл иргэдийг түр хоноглуулах байраар шуурхай хангах, харин удаан хугацаанд гэр оронгүй байсан иргэдэд нөхөн сэргээх үйлчилгээ болон эрчимт түр хоноглох байр, шилжин суурьшигчдад улирлын чанартай орон байр, байрны орц, хонгил зэрэгт амьдарч буй иргэдэд онцлог тохируулга бүхий зохицуулалт гаргах гэх мэт холимог арга хэмжээ авах нь зүйтэй гэжээ.

Монгол Улсын хувьд ч тэнэмэл иргэдийг өвлийн улиралд түр хоноглуулах хэлбэрийн үйлчилгээнээс өөр гэр оронгүй иргэдэд чиглэсэн далайцтай арга хэмжээ байхгүй байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүсч буй зуд, ган гачиг, үерийн аюулаас үүдэлтэй гэр оронгүйдлийн үзэгдэл нэмэгдэх эрсдлүүд хот, хөдөөгүй байгааг шийдвэр гаргагчид анхааралдаа авах цаг болсон гэж үзэж байна. Иймд, олон улсад хэрэгжүүлдэг *гэр оронгүйдлээс урьдчилан сэргийлэх*, гэр оронгүйдэлд өртсөн иргэдэд *анхдагч хэрэгцээг нь хангах яаралтай тусламжийг* оновчтойгоор үзүүлэх хөтөлбөрүүдийн сайн туршлагаа судлан Монгол Улсад хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд, ялангуяа 1) Гэр оронгүй иргэдийн талаарх ойлголт, тодорхойлолтуудыг холбогдох хууль, дүрэм, захиргааны бүртгэл, статистик хөтлөх аргачлалд тусгах; 2) Гэр оронгүйдэлд өртөж буй өрх, хүн амын тоо мэдээллийг нарийвчлан бүртгэж, гаргадаг болох; 3) Гэр оронгүй болоход нөлөөлж байгаа хувь хүн, гэр бүл, нийгмийн түвшний хүчин зүйлсийг тогтмол судлан, төлөвлөлт, хяналт, шинжилгээнд ашигладаг болох; 4) Тогтолцооны холбоотой гэр оронгүйдлийн хүчин зүйлсийг таслан зогсооход чиглэсэн хариу арга хэмжээ, интервенцийг хэрэгжүүлэх чадавх, нөөцийг бий болгох шаардлагатай байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- 58th UN Commission for Social Development. (2020). *Affordable housing and social protection systems for all to address homelessness*. Retrieved from //documents-dds-ny.un.org/doc/UNDOC/LTD/N20/037/48/PDF/N2003748.pdf?OpenElement
- 58th UN Commission for Social Development. (n.d.). *Affordable housing and social protection systems for all to address homelessness (report of the Secretary-General)*. Retrieved April 27, 2022, from <https://digitallibrary.un.org/record/3840349?ln=en>
- Agans, R., Liu, G., Jones, M., Verjan, C., Silverbush, M., & Kalsbeek, W. (2015). *Public Attitudes Toward the Homeless*.
- Aleksandra Tkaczyk, Z. B. (2010). Cultural dimensions analysis.

- Carol, A., Christopher, A., Magee, & Peter, J.K. (2016). *Is there a complex trauma experience typology for Australians experiencing extreme social disadvantage and low housing stability?* Retrieved from Child Abuse & Neglect.
- Charlotte Fry et al. (2017). A systematic review of cognitive functioning among young people who have experienced homelessness, foster care, or poverty. *Child Neuropsychology*, 23(8), 907-934.
- Development, 5. U. (2020). *Affordable housing and social protection systems for all to address homelessness*. Retrieved from //documents-dds-ny.un.org/doc/UNDOC/LTD/N20/037/48/PDF/N2003748.pdf?OpenElement
- Harman, G. (2008). *On the Horror of Phenomenology: Lovecraft and Husserl*.
- Hazel R. Markus, S. K. (2008). Culture and the Self.
- IOM, SDC, UNU-MERIT, PTRC. (2018). *Монгол Улс: Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа*. Улаанбаатар.
- Keane CA, M. C. (2016; 61:43–54.). Is there a complex trauma experience typology for Australians experiencing extreme social disadvantage and low housing stability? *Child Abuse Negl*.
- Mabhala, M.A., Basma, Ellahi., Alan, M., & Paul, K. (2016). *Understanding the determinants of homelessness through examining the life stories of homeless people and those who work with them: a qualitative research protocol*.
- Oppenheimer, Sarah, C., Paula, S., Nurius, & Green, S. (2016, July). Homelessness History Impacts on Health Outcomes and Economic and Risk Behavior Intermediaries: New Insights from Population Data. *Families in Society*, 97(3), 230-242. doi:https://doi.org/10.1606/1044-894.2016.97.21
- Solongo, A. (2020). Internal migration in Mongolia. In A. B.-E. Martin Bell, *Internal Migration in the Countries of Asia, A Cross-national Comparison* (pp. 77-91).
- Spector, P. E. (2004). *Industrial and organizational Psychology*. New York.
- Suzanne. (2020). The state of homelessness in developing countries (presentation). *Expert group meeting on affordable housing and social protection systems for all to address homelessness*. Nairobi.
- Sylvestre J., Kerman, N., Polillo, A., Lee, C.M., Aubry, T., & Czechowski, K. (2018). A Qualitative Study of the Pathways Into and Impacts of Family Homelessness. *Journal of Family Issues*, 39(8), 2265-2285. doi:10.1177/0192513X1774670
- Tan, H., Forbes-Mewett, H. (2018). Whose 'fault' is it? Becoming homeless in Singapore . *Urban Studies*, 55(16), 3579-3595. doi:10.1177/0042098017743723
- АХБ & Когнос Интернейшнл. (2022). “Улаанбаатар хотын гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг үнэлэх түргэвчилсэн судалгааны тайлан. хэвлэгдээгүй тайлан.
- АХБ. (2019). *Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй, оршин суугаа газрын тодорхой хаяггүй, иргэний бичиг баримтгүй иргэдийг бүртгэлжүүлэх арга зам*. Улаанбаатар.
- НЗДТГ, Нийгмийн бодлогын хэлтэс. (2022). *Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс Улаанбаатар хотын бүх дүүрэг, хороодоос явуулсан тооллогын нэгдсэн дүн*. Retrieved 03 22, 2022, from <http://ubstat.mn/StatTable=25>
- НХТТ. (2021). *НХТТ-ийн үйл ажиллагааны тайлан*.
- НХХЯ, ХАССТ, НҮБХАС. (2009). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар*. Улаанбаатар: “Бит пресс” ХХК.
- ОУШХБ, IRIM. (2021). *Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа*. Улаанбаатар.
- ҮСГ, НҮБХАС. (2007). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чанарын судалгаа*. Улаанбаатар.



- ҮСХ. (2013). *Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал*. Улаанбаатар.
- ҮСХ. (2020). *Орон сууцны төрөл, ашиглалт, ахуйн нөхцөл (сэдэвчилсэн судалгаа)*. Улаанбаатар.
- ҮСХа. (2011). *Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Нэгдсэн дүн*. Улаанбаатар: BCI Хөгжлийн компани.
- ҮСХб. (2011). *Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Орон сууцны ахуйн нөхцөл (сэдэвчилсэн судалгаа)*. Улаанбаатар: BCI хөгжлийн компани.
- ХАССТ, НҮБ-ын МИТЭЗНСХ, ОУШХБ. (2021). *Монгол Улс: Шилжилт хөдөлгөөн ба Хөдөлмөр эрхлэлт*. Улаанбаатар.
- ХАССТ, НХХЯ, НҮБХАС. (2004). *Улаанбаатар хотын шилжих хөдөлгөөн ба ядуурал*. Улаанбаатар.
- ХНХЯ. (2010). *Шилжих хөдөлгөөн ба хот, суурины аюултай бүс, орцонд амьдарч буй гэр бүл (НХХЯ-ны хэвлэгдээгүй судалгааны тайлан)*.
- ХНХЯ, ХАССТ, НҮБХАС. (2001). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа*. Улаанбаатар: “Эдо принтинг” ХХК.
- ЭМШУИС, НҮБХАС, Япон Улсын Засгийн газар. (2007). *Шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн байдал, тусламж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ*. Улаанбаатар.